

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТЭС

ИЛТГЭХ ХУУДАС

Сэтгэл ханамжийн судалгааны дүнгийн тухай

2021.09.13

Улаанбаатар хот

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, хэрэглэгчдийн санал хүсэлтийг нээлттэйгээр хүлээн авч, хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор сэтгэл ханамжийн судалгааг нийслэлийн засаг захиргааны байрууд, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдаас 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд цахим болон цаасан хэлбэрээр зохион байгууллаа. Судалгааны дүнг нэгтгэвэл:

1. Цэвэрлэгээ, үйлчилгээний талаар





График 1. Өрөө тасалгааны цэвэрлэгээ үйлчилгээний талаарх санал асуулгын дүн

Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, үйлчилгээнд өгсөн үнэлгээ /тоо/



Байруудын нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, үйлчилгээнд өгсөн үнэлгээний харьцуулалт /коэффициент/




График 2. Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ үйлчилгээний талаарх санал асуулгын дүн

Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээнд өгсөн үнэлгээ /тоо/



Байруудын ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээнд өгсөн үнэлгээний харьцуулалт /коэффициент/




График 3. Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээний талаарх санал асуулгын дүн

2. Цар тахлын үеийн зохион байгуулсан ажлын талаар

Цар тахлын үеийн ариутгал, цэвэрлэгээ үйлчилгээнд өгсөн үнэлгээ /тоо/



Байруудын цар тахлын үеийн ариутгал, цэвэрлэгээ үйлчилгээнд өгсөн үнэлгээний харьцуулалт /коэффициент/




График 4. Цар тахлын үеийн ариутгал, цэвэрлэгээ үйлчилгээний талаарх санал асуулгын дүн

Цаашид /ковид-19/ цар тахлын үед хамтарч хэрэгжүүлэх санал:

Цар тахалын үед хамтарч хэрэгжүүлэх санал



Ирүүлсэн гол саналууд:

1. Ариутгал, халдваргүйжүүлэлт тогтмол хийх
2. Ковид туссан хүмүүст нөхөн сэргээх эмчилгээнд коктейлээр үйлчлэх
3. Гадны хүмүүсийг нэвтрүүлэхгүй байх
4. Агааржуулалтыг сайжруулах
5. Ковид-19-ийн дельта хувилбарын талаар мэдээлэл байршуулах

3. Зоогийн газрын үйлчилгээний талаар





График 5. Зоог, цайны газрын хоолны нэр төрөл, амт чанарын талаарх санал асуулгын дүн



График 6. Цайны цагаас бусад цагт захиалгат хоолны үйлчилгээг дэмжих эсэх талаарх санал асуулгын дүн

4. Байр ашиглалтын талаар

Цахилгаан хангамжийн хэвийн найдвартай ажиллагаанд өгсөн үнэлгээ /тоо/



Байруудын цахилгаан хангамжийн хэвийн найдвартай ажиллагаанд өгсөн үнэлгээний харьцуулалт /коэффициент/




График 7. Цахилгаан хангамжийн хэвийн ажиллагааны талаарх санал асуулгын дүн

Халуун, хүйтэн ус, сантехникийн шугам сүлжээний хэвийн ажиллагаанд өгсөн үнэлгээ /тоо/



Байруудын халуун, хүйтэн ус, сантехникийн шугам сүлжээний хэвийн ажиллагаанд өгсөн үнэлгээний харьцуулалт /коэффициент/





График 8. Халуун, хүйтэн ус, сантехникийн шугам сүлжээний хэвийн ажиллагааны талаарх санал асуулгын дүн

Цахилгаан, сантехник, холбоо, мужааны дуудлагын үйлчилгээнд өгсөн үнэлгээ /тоо/



Байруудын цахилгаан, сантехник, мужааны дуудлагын үйлчилгээнд өгсөн үнэлгээний харьцуулалт /коэффициент/





График 9. Цахилгаан, сантехник, мужааны дуудлагын үйлчилгээний талаарх санал асуулгын дүн

Үйлчилгээний ажилтнуудын харилцаа, хандлагын үнэлгээ /Нэг од-Хангалтгүй, Зургаан од-Сайн/



Байруудад ажиллаж байгаа үйлчилгээний ажилтнуудын харилцаа, хандлагд өгсөн үнэлгээний харьцуулалт /коэффициент/




График 10. Үйлчилгээний ажилтнуудын харилцаа, хандлагын талаарх санал асуулгын дүн




График 11. Ажилтнуудын ур чадварт өгсөн санал асуулгын дүн

Санал асуулгад оролцсон ажилтан, албан хаагчдаас гаргасан зарим санал, хүсэлт:

НЗЗ-ны 1-р байр:

- Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээг сайжруулах,
- Ариун цэврийн өрөөнд саван, гарын цаасыг тогтмол хүртээмжтэй байлгах,
- Цайны газрын хоолны нэр төрөл, амт чанарыг сайжруулах,
- Цайны газрын тогооч нарын харилцаанд анхаарах,
- Аяга таваг, халбага сэрээг зориулалтын угаагч машинаар угаадаг болох,

НЗЗ-ны 2-р байр

- Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээг сайжруулах,
- Хоолны нэр төрлийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах,
- Ажилтнуудын харилцаанд анхаарах,

НЗЗ-ны 3-р байр

- Цонхны тавцанд тавьсан хулдаасыг солих,
- Үйлчилгээний ажилтнууд харилцаа, хандлагадаа анхаарах
- Цахилгааны шугам, сүлжээний асуудлыг шийдвэрлэх,

НЗЗ-ны 4-р байр

- Барилгын агаар сэлгэлтийн системийг ажиллуулах,
- Хог хаягдлыг ангилан ялгах,

НЗЗ-ны 5-р байр В корпус
- Цонх дулаалах,

НҮНТ-ийн Драгон салбар
- Агааржуулалт сайжруулах,

Дүгнэлт

Тус сэтгэл ханамжийн судалгааг НЗЗ-ны байрууд болон НҮНТ-ийн салбаруудад ажиллаж байгаа 860 ажилтан, албан хаагчид оролцож санал хүсэлтээ өглөө. Санал асуулгыг НЗЗ-ны байруудад байрлаж байгаа ажилтан, албан хаагчдаас цахим хэлбэрээр, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу дэд төвд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдаас цаасаар авч дүнг нэгтгэсэн.

1. Өрөө тасалгааны цэвэрлэгээ үйлчилгээнд сайн үнэлгээ өгсөн 563, дунд 253, хангалтгүй 44 үнэлгээг тус тус өгсөн байгаа нь цэвэрлэгээ үйлчилгээнд сэтгэл хангалуун байгааг харуулж байна. Байруудын харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны 5-р байрны А, Б корпус, НҮНТ-ийн Мишээл, Дүнжингарав, Драгон салбарууд, Баянхошуу дэд төвд ажиллаж байгаа албан хаагчид өрөө тасалгааны цэвэрлэгээнд хамгийн сэтгэл хангалуун байсан ба 2-р байрны өрөө тасалгааны цэвэрлэгээнд илүү анхаарах шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна.

2. Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, үйлчилгээнд сайн үнэлгээ өгсөн 569, дунд 256, хангалтгүй 34 үнэлгээг тус тус өгсөн байна. Харин байруудын санал өгсөн байдлыг харьцуулж харахад НЗЗ-ны 2, 3, 4-р байрны нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээнд илүү анхаарах шаардлагатай байна.

3. Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээний талаарх асуулгад сайн 531, дунд 269, хангалтгүй 60 үнэлгээг өгсөн. Харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны 1, 2, 3 дугаар байруудын ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээнд анхаарах шаардлагатай байна.

4. Цар тахлын үеийн зохион байгуулж байгаа ажлын талаарх санал асуулгад сайн 517, дунд 271, хангалтгүй 67 үнэлгээг тус тус өгсөн байна. Харин байруудын санал өгсөн байдлыг харьцуулж үзэхэд НЗЗ-ны 2, 3, 4 дүгээр байруудад ажил сайжруулах шаардлагатай байгаа нь санал асуулгад оролцогчдын хариултаас харагдаж байна.

5. Зоогийн газрын үйл ажиллагаанд НЗЗ-ны 1, 2, 5 дугаар байрны ажилтан, албан хаагчид санал өгсөн бөгөөд хоолны нэр төрөл, амт чанарт сайн 106, дунд 231, хангалтгүй 94 үнэлгээг тус тус өгсөн байгаа нь хоолны амт чанарт сэтгэл дундуур байна.

6. Цайны цагаас бусад цагт захиалгат хоолны үйлчилгээг дэмжих эсэх санал асуулгад нийт саналын 90 хувь нь дэмжсэн хариулт өгсөн байна.

7. Байруудын цахилгаан хангамжийн хэвийн, найдвартай ажиллагаанд сайн 559, дунд 167, хангалтгүй 30 үнэлгээг өгсөн байна. Харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны 3-р байрны цахилгаан хангамжийн хэвийн найдвартай ажиллагаанд бусдаасаа доогуур үнэлгээ өгсөн байна.

8. Байруудын халуун, хүйтэн ус, сантехникийн шугам, сүлжээний хэвийн ажиллагаанд сайн 448, дунд 262, хангалтгүй 50 үнэлгээг өгсөн байна. Харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны 3-р байрны халуун, хүйтэн ус, сантехникийн шугам сүлжээний хэвийн ажиллагаанд бусдаасаа доогуур үнэлгээ өгсөн байна.

9. Дуудлагын үйлчилгээний талаарх асуулгад сайн 580, дунд 236, хангалтгүй 29 гэсэн үнэлгээг тус тус өгсөн. Харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны 3 дугаар байруудын дуудлагын үйлчилгээнд анхаарах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

10. Үйлчилгээний ажилтнуудын харилцаа, хандлагад зургаан одтой 225, таван одтой 86, дөрвөн одтой 48, гурван одтой 20, хоёр одтой 21 үнэлгээтэй тус тус үнэлсэн байна. Байруудын үйлчилгээний ажилчдын харилцаа, хандлагыг харьцуулж үзвэл НЗЗ-ны 3, 4, 5-р байрны А корпусын ажилтнууд харилцаа, хандлагадаа анхаарах шаардлагатай байна.

11. Үйлчилгээний ажилтнуудын ур чадварт зургаан одтой 245, таван одтой 104, дөрвөн одтой 51, гурван одтой 14, хоёр одтой 25 үнэлгээтэй тус тус үнэлсэн байна. Байруудын үйлчилгээний ажилчдын ур чадварыг харьцуулан үзвэл НЗЗ-ны 2, 3, 5-р байрны В корпусын ажилтнууд ур чадвараа сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатай гэж үзсэн нь судалгаанаас харагдаж байна.

12. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ




График 12. Цэвэрлэгээ, үйлчилгээнд өгсөн үнэлгээ



График 13. Зоог, цайны газрын үйл ажиллагааны чигэлээр өгсөн үнэлгээ

Байр ашиглалтын үйл ажиллагаа



График 14. Байр ашиглалтын чиглэлээр өгсөн үнэлгээ

13. Байгууллагын үйл ажиллагаанд өгсөн нэгдсэн дүн

Байгууллагын үйл ажиллагаа




График 15. Байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

Нэгдсэн дүнгээс харахад манай байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг дийлэнх хэсэг нь сайн гэж үнэлсэн бөгөөд цаашид дунд, хангалтгүй үнэлгээг бууруулахад анхаарч, төрийн албан хаагчдаас гаргасан санал, гомдлыг судлан үзэж, шийдвэрлэн ажиллах болно.

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ

ИЛТГЭХ ХУУДАС ХҮЛЭЭН АВСАН:
БАЙР АШИГЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА

Г.БАТЗАЯА

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА

Л.УРАНХАЙЧ